



VII-IX/2021

Тархаасан: 2021 оны 10 дугаар сарын 12




## Зочид буудлын салбарын үйлдвэрлэгчийн үнэ өмнөх улирлаас 0.5 хувиар өслөө

Зочид буудлын салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс (2015=100) 2021 оны 3 дугаар улиралд 128.5 болж, үнэ өмнөх оны мөн үеэс 2.0 хувь, өмнөх оны эцсээс 1.8 хувиар тус тус буурсан байна. Харин өмнөх улирлаас 0.5 хувиар өссөн байна.

Нийтийн хоолны салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс (2015=100) 2021 оны 3 дугаар улиралд 109.0 болж, үнэ өмнөх оны мөн үеэс 2.2 хувь, өмнөх оны эцсээс 2.1 хувь, өмнөх улирлаас 0.7 хувиар тус тус өссөн байна.

ЗУРАГ 1. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛНЫ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС (2015=100), улирлаар, хувиар



Зочид буудлын салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс өмнөх улирлаас 0.5 хувиар өсөхөд богино хугацаагаар байр, сууцаар хангах үйл ажиллагааны дэд салбарын үйлдвэрлэгчийн үнэ 0.4 хувиар өссөн нь голлон нөлөөллөө.

ХҮСНЭГТ 1. ЗОЧИД БУУДАЛНЫ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС, дэд салбараар, хувиар

Дэд салбар	<u>2021 VII-IX</u> 2015	<u>2021 VII-IX</u> 2020 VII-IX	<u>2021 VII-IX</u> 2021 IV-VI
	2015=100		
<b>Ерөнхий индекс</b>	<b>128.5</b>	<b>98.0</b>	<b>100.5</b>
Богино хугацаагаар байр, сууцаар үйлчлэх үйл ажиллагаа	128.2	97.9	100.4
Автомашин зогсоол бүхий зуслан, чөлөөт цаг өнгөрөөх хоноглох байраар хангах үйл ажиллагаа	161.7	100.8	101.5
Бусад төрлийн байраар хангах үйл ажиллагаа	99.7	101.8	101.8

Зочид буудлын салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс өмнөх улирлаас 0.5 хувиар өсөхөд нийслэлийн зочид буудлын үйлчилгээ эрхлэгч ААН-ийн үйлдвэрлэгчийн үнэ 0.3 хувиар өссөн нь голлон нөлөөллөө.

ХҮСНЭГТ 2. ЗОЧИД БУУДЛЫН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС, аймаг, нийслэлээр, хувиар

Дэд салбар	2021 VII-IX 2015	2021 VII-IX 2020 VII-IX	2021 VII-IX 2021 IV-VI
	2015=100		
Ерөнхий индекс	128.5	98.0	100.5
Нийслэл	128.7	98.1	100.3
Аймаг	127.6	98.0	101.7

Нийтийн хоолны салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс өмнөх улирлаас 0.7 хувиар өсөхөд нийслэлийн нийтийн хоолны үйлчилгээ эрхлэгч ААН-ийн үйлдвэрлэгчийн үнэ 0.7 хувиар өссөн нь голлон нөлөөллөө.

ХҮСНЭГТ 3. НИЙТИЙН ХООЛНЫ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС, аймаг, нийслэлээр, хувиар

Дэд салбар	2021 VII-IX 2015	2021 VII-IX 2020 VII-IX	2021 VII-IX 2021 IV-VI
	2015=100		
Ерөнхий индекс	109.0	102.2	100.7
Нийслэл	108.5	101.8	100.7
Аймаг	112.3	104.8	100.7

Ойлголт, тодорхойлолт

Үйлдвэрлэгчийн үнийн индекс

Тухайн үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг илэрхийлнэ.

Индексийн жин

Индексийн тооцоонд ашиглах жинг тухайн бүтээгдэхүүний нийт борлуулалтын хэмжээнд эзэлж буй хувийн жингээр тооцно.

Тооцох аргачлал

Үйлдвэрлэгчийн үнийн индексийн тооцоонд Ласпейрсийн үнийн индексийг хэрэглэнэ.

$$I_p^t = \frac{\sum_{i=1}^n (p_t^i * q_0^i)}{\sum_{i=1}^n (p_0^i * q_0^i)}$$

Үүнд:

$I_p^t$  –  $t$  тайлант үеийн Ласпейрсийн үнийн индекс

$t$  – тайлант үе

$0$  – суурь үе

$p_t^i$  –  $i$  барааны тайлант үеийн үнэ

$p_0^i$  –  $i$  барааны суурь үеийн үнэ

$q_0^i$  –  $i$  барааны суурь үеийн худалдан авсан тоо



## Эх үүсвэр

ҮСХ, Зочид буудал, нийтийн хоолны салбарын үйлдвэрлэгчийн үнийн мэдээ

## Ангилал, код

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал,  
Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн ангилал

## Мэдээлэл авах холбоос

<http://www.nso.mn/>  
<http://www.1212.mn/>

## Дараагийн мэдээ тархаах хуваарь

2022 оны 1 дүгээр сарын 14

Эдийн засгийн статистикийн газрын  
дарга А.Дэмбэрэл  
Утас : (976-51)-329271

Эдийн засгийн статистикийн газрын  
статистикч Г.Мөнх-Оргил  
Утас : (976-51)-261559

